

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНД БАЙРЛАХ АЙВИКО ХХК
“ТАРИЛГЫН ЭМИЙН ҮЙЛДВЭР”-ИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР 2809427/

1. Төслийн товч танилцуулга

Монгол, Их Британи, Австрали, Тайванийн хамтарсан хөрөнгө оруулалттай “АЙВИКО” ХХК, Улсын бүртгэлийн дугаар 9019005135, Регистрийн дугаар: 2809427

2004 он хүртэл тарилгын эм эмийг үйлдвэрлэлийн бус эмнэлгийн орчинд, эрүүл ахуйн шаардлагыг үл хангах нөхцөлд хийх болон импортлох замаар хангаж байсныг халж, Монгол улсад эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай олон улсын шаардлагад нийцсэн тарилгын эм ийг эх орондоо үйлдвэрлэх зорилгоор АйВиКо тарилгын эмийн үйлдвэр нь 2004 онд Монгол, Их Британи, Австрали, Тайвань, БНСУ-ын хамтарсан хөрөнгө оруулалттай байгуулагдсан.

Тарилгын эмийн үйлдвэр нь Олон улсын болон Үндэсний “Эм үйлдвэрлэлийн зохистой дадал –GMP” хангасан үндэсний томоохон эмийн үйлдвэр бөгөөд хүн ам, эрүүл мэндийн байгууллагыг эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй чанарын баталгаатай, сонголт хийх боломж бүхий эмээр тасралтгүй, жигд, хүртээмжтэй хангаж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилготой.

“Айвико” тарилгын эмийн үйлдвэр нь зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон 41, нийт 68 нэрийн тарилгын эмийг үйлдвэрлэж, хүн ам, эрүүл мэндийн байгууллагыг хангаж ажилладаг олон улсын болон үндэсний “Эм үйлдвэрлэлийн зохистой дадал- GMP”-ын шаардлага хангасан анхны эмийн үйлдвэр билээ.

Тус үйлдвэр байгуулагдсан цагаас эхлэн “Эм үйлдвэрлэлийн зохистой дадал – GMP”-ын дүрэмд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж ирсэн бөгөөд 2013 онд эм үйлдвэрлэх бүхий л үйл ажиллагааны уялдаа холбоо, нэгдмэл байдлыг хангаж, чанарын хяналтын тогтолцоог нэвтрүүлж ажилласны үр дүнд эмийн түүхий эдээс эхлэн эцсийн бүтээгдэхүүн хэрэглэгчдэд очих хүртэлх бүх шат дамжлага нь эмийн чанар, аюулгүй байдлыг бүрэн хангаж, эрсдэлгүй бүтээгдэхүүнээр хүн амаа хангах нөхцлийг бүрдүүлсэн болохыг нотолж олон улсын Certipharm компанийн аудитаас GMP батламж авсан болно.

Мөн тус үйлдвэр “Эм үйлдвэрлэлд тавигдах ерөнхий шаардлага MNS 5524:2014” стандарт буюу үндэсний GMP–ийн шаардлагыг хангасан болохыг батламжилж Эрүүл мэнд, спортын яамнаас 2015 онд “Үндэсний GMP батламж №01”-ийг олгосон.

Үйлдвэрлэлийн байрны зохион байгуулалтын зургийг АНУ-ын “Ромако” группын Франц дахь IPM компани 2004 онд хийж модуль, үйлдвэрлэл, чанарын хяналтын тоног төхөөрөмжүүд, холболтын хоолой, цахилгааны кабель, щит зэргийг нийлүүлж, угсарсан.

Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлж, 2009 онд БНСУ-ын Fine FACompany-н тоног төхөөрөмжүүд шинээр суурилуулсан. 2013 онд полипропилен савлагаатай тарилгын уусмал үйлдвэрлэх шинэ шугам ашиглалтанд оруулсан. 2017 онд Non PVC савлагаатай тарилгын эм үйлдвэрлэх шугамыг шинээр ашиглалтанд оруулсан.

“АйВиКо” тарилгын эмийн үйлдвэр нь 1728м² талбай бүхий “Эм үйлдвэрлэлийн зохистой дадал – GMP”-ын шаардлагад нийцсэн байртай. Үйлдвэрлэлийн байрыг байшингийн доторх байр буюу эмийн үйлдвэрлэлийн модулийн зарчмаар “эмийн үйлдвэрлэлийн зохистой дадал GMP”-ын шаардлагын дагуу угсарч хийсэн. Үүнд:

- Их эзэлхүүнтэй тарилгын эмийн үйлдвэр – 330м²
- Бага эзэлхүүнтэй тарилгын эмийн үйлдвэр – 198м²
- Техникийн засвар үйлчилгээ хийх тусгай өрөөнүүдтэй – 104м²
- Туслах үйлдвэрлэлийн байр – 104м²
- Чанарын хяналтын лаборатори – 92 м²

Монгол улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын төлөвлөгөөт хяналт шалгалтанд 2018 оны 10 сард хамрагдсан. Уг хяналт шалгалтаар эрсдлийн үнэлгээ 6.5% буюу эрсдэл багатай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 93% буюу хангалттай гэсэн үнэлгээг тус тус авсан болно.

Агааржуулалтын систем

Үйлдвэрлэлийн модулийг АНУ-ын “Ромако” группын Франц дахь IPM компани нийлүүлж, угсарсан. Олон улсын стандартын байгууллагын ISO5, ISO7, ISO8 ангиллын шаардлагад нийцсэн, олон дамжлагаар шүүж ариутгасан агаараар хангагдсан өрөөнүүдтэй.

Үйлдвэрлэлийн модулийн гаднах том танхимыг G4 (том биетийн 90%), F7 (жижиг биетийн 80%), F9 (жижиг биетийн 95%) шүүлтүүрүүд бүхий иж бүрэн автомат тохируулга, удирдлагатай “Венто” кондиционерийн систем шүүсэн агаараар хангадаг. Энэхүү систем нь шүүсэн агаарыг үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагдах агаарын цэвэршилтийн В, С, D өрөөнүүдэд агаарын даралтыг шатлан бууруулсан, шүүсэн, нягтруулсан агаараар хангах бөгөөд эдгээр өрөөнүүдэд гаднаас агаарын бохирдол орохгүй байх нөхцлийг бүрдүүлсэн.

Эмийн түүхий эд жинлэх, уусмал тунлан савлах, битүүмжлэх өндөр эрсдэлтэй үйл ажиллагааг явуулах А бүсийн агаарыг эцсийн шатанд H14 буюу 99.995% шүүх HEPA шүүлтүүрээр шүүдэг.

Агуулах

Химийн бодисын агуулах нь хадгалах бодисын хэмжээнээс хамаарч гал түймэр гарах тохиолдолд нэгээс нь нөгөөд хүргэхгүй унтраах боломжтой зайд байрласан өрөөтэй, өрөө нь дотроо хамт хадгалж болох бүлэг, бүлгийн бодисуудыг тус тусад нь хадгалах зориулалттай өөр хооронд нь тусгаарласан тасалгаатай.

Химийн материалыг галын аюулаас урьдчилан сэргийлэх бүх нөхцөлөөр хангагдсан агааржуулалттай, цемент, төмөр бетон шалтай ус, чийг орохгүй агуулахад хадгалагдана. Агуулахын температур нь 0-20°C байна. Химийн урвалж, бодисуудыг тодорхой газар зориулалтын саванд хадгалдаг бөгөөд химийн урвалжтай савыг сайтар бөглөн, нэр хаяг тавьж хадгалдаг.

Хортой химийн бодисуудыг цоожтой тусгай шүүгээнд зохих дүрэм, зааврын дагуу хадгална. Шатамхай, амархан дөл авалцдаг, нам температурт буцалдаг шингэнийг зузаан ханатай шилэн саванд асбестээр шавсан таглаа сайтай төмөр хайрцагт хийж уг хайрцагийг гадагш гарах хаалганы эсрэг талд ил гал, оч, гаргагч цахилгаан хэрэгсэл, дулаан үүсгэгч багаж, бусад дулааны хэрэгслээс хол байрлуулдаг.

Химийн материалыг хүлээн авсны дараа нэр төрлөөр нь ангилан, агуулахын хананаас 0.4 м зайтай хураана. Материалын жин 100 кг-аас хэтрэхгүй байвал 2 давхарлан хурааж болно. Өөр төрлийн материалуудын хоорондох зай 1.5-2 м байна. Амархан ууршдаг химийн материалыг хадгалахад савны бөглөө таг суларч хөндийрсөн эсэхийг сайтар шалгана.

Хог хаягдал

✚ Ахуйн хог хаягдал: Төслийн талбайд үйлдвэрлэлийн бүхий л үе шатаас гарах хог хаягдлыг хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх талаас анхаарч урьдчилсан сэргийлэх, хязгаарлах, хамгаалах, дахин ашиглах арга хэмжээг төлөвлөж удирдлага зохион байгуулалтаар хангаж зохицуулан ажиллах нь чухал гэж үзлээ. Ингэснээр хог хаягдал үүсгэгч этгээд /ажилтан, алба нэгж/-ийн хог хаягдлын зохистой хэрэглээг хэвшүүлсэнээр хүрээлэн буй орчны бохирдлоос сэргийлэх, төслийн үйл ажиллагааны уялдаа зэрэг эерэг үр дүнтэй. “Айвико” ХХК-ийн тарилгын эмийн үйлдвэрт нийт 129 ажилтан ажиллахаар төлөвлөгдөж байгаа ба 1 хүн хоногт дундажаар 1.5 кг хатуу хог хаягдал гаргадаг гэж тооцвол жилд ойролцоогоор 61.9 тн ахуйн хатуу хог хаягдал гарна. Үүнд: төрөл бүрийн цаас, хоол хүнсний сав баглаа боодол, хоол хүнсний үлдэгдэл зэрэг орно.

“Айвико” ХХК-ийн тарилгын эмийн үйлдвэрт нийт 129 ажилтан ажиллахаар төлөвлөгдөж байгаа ба 1 хүн хоногт дундажаар 1.5 кг хатуу хог хаягдал гаргадаг гэж

тооцвол жилд ойролцоогоор 61.9 тн ахуйн хатуу хог хаягдал гарна. Үүнд: төрөл бүрийн цаас, хоол хүнсний сав баглаа боодол, хоол хүнсний үлдэгдэл зэрэг орно.

Гүйцэтгэх захирлын 2009 оны 04-р сарын 29-ны 014 тоот тушаалаар хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах журам баталж хог хаягдлыг тээвэрлэн хаях ажлыг гүйцэтгүүлэхээр Хан-Уул дүүргийн Тохижилт үйлчилгээ ХХК-тай гэрээ байгуулсан.

✚ Тусгай хог хаягдал:

Үйлдвэрлийн явцад гарч буй тусгай хог хаягдлыг:

- Үйлдвэрлэлийн явцад гарсан гологдол бүтээгдэхүүн;
- Лабораторийн сорилт шинжилгээнээс гарсан химийн урвалж бодис, тэжээлт орчин, өсгөвөр, зүү тариур;
- Эцсийн бүтээгдэхүүн, эмийн түүхий эдийн хяналтын дээж;
- Зах зээлээс буцаан татсан бүтээгдэхүүн болон хугацаа дууссан бүтээгдэхүүн;
- Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн түүхий эдийн сав баглаа боодол;

гэж ангилан тусгай уут болон саванд хийн зориулалтын цэгт цуглуулж, “Эм, эмийн гаралтай химийн бүтээгдэхүүн болон эмнэлгийн туслах материал тээвэрлэх, устгах” гэрээний дагуу “Элемент” ХХК-аар устгуулдаг.

Лабораторийн шинжилгээнээс гарсан химийн урвалж бодис, шинжилгээнд ашигласан шил сав буюу лабораторийн тусгай хаягдлыг Монгол Улсын Эрүүл Мэндийн сайд, Байгаль орчны сайдын 2002 оны 249/201 тоот тушаалын 6.1-ийн дагуу

- Өндөр даралттай уураар халдваргүйжүүлэх
- Химийн аргаар халдваргүйжүүлэх, саармагжуулах, хоргүйжүүлэх


аргыг хэрэглэн халдваргүйжүүлж саармагжуулдаг.

Ахуйн болон тусгай хог хаягдлыг үйлдвэрлэлийн байр, оффист 24 цагаас дээш, хог хаягдлыг хог хадгалах байранд 20 хоногоос дээш хугацаагаар хадгалахыг хориглосон байна. Мөн химийн бодис болон эмийн түүхий эдийг 1 сар хамгийн ихдээ 3 сарын нөөцлөх төлөвлөгөө гарган хэрэгжүүлснээр химийн бодис болон эмийн түүхий эдийн хаягдал гарахгүй байх боломжтой болсон.

1. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт Үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах тухай 2005 оны 1-р сарын 04-ний өдрийн 1/2005 гэрээ /хавсралт/, “Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад

эрхийн улсын бүртгэлийн Y-2206006352 дугаартай гэрчилгээ"-тэй газарт хэрэгжиж байна. Солбицол нь: 47°53'45.9", 106°52'36.2



Зураг 1. Төслийн талбайн агаар сансрын зураг

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Өөрийн компанийн байранд, утас: 11-345731, Факс: 11-345734, "Айвико" ХХК-ийн гүйцэтгэх захирал Л. Цэрэндорж

Хүчин чадал

2022 оны байдлаар 129 ажилтантай PVC болон non PVC савлагаатай 38 нэрийн их эзэлхүүнтэй тарилгын эм, ПП (полипропилен) савлагаатай 28 нэрийн бага эзэлхүүнтэй тарилгын эмийг тус тус үйлдвэрлэн Бид улсын болон хувийн хэвшлийн 1700 орчим эрүүл мэндийн байгууллагуудад бүтээгдэхүүнээ нийлүүлдэг.

- Их эзэлхүүнтэй тарилгын эмийн үйлдвэрлэлийн шугам: Жилд 10 сая ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд хоногт 16 цаг, сард 27 хоног, жилд 320 хоног,
- Бага эзэлхүүнтэй тарилгын эмийн үйлдвэрлэлийн шугам: Жилд 8 сая ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд хоногт 8 цаг, сард 22 хоног, жилд 264 хоног тус тус ажиллаж байна.
- Мөн гемодиализын эмчилгээний 9 нэрийн уусмал, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд 7 нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг.

2. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Энэхүү төслийн байршил үйлдвэрийн бүсэд байрлах бөгөөд тус төслийн талбай орчим ургамлын төрөл зүйл, амьтны зүйл байхгүй юм. Үйлдвэрлэлийн явцад болзошгүй тохиолдлоор аюулгүй ажиллагаа алдагдах, үйлдвэрлэлийн процессын алдаа гарах тохиолдолд тухайн орчны агаарын чанарт сөргөөр нөлөөлөх боломжтой юм.

Химийн бодисын агуулах нь MNS 6458:2014 стандартын шаардлагыг бүрэн хангасан бөгөөд эргэн тойрон хатуу хучилттай талбайтай учраас хөрс, ургамлан нөмрөг, амьтны аймаг зэрэгт нөлөөлөл үзүүлэхгүй.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг	Боломжит / болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн тохиолдолын магадлал/ давтамж	Зэрэглэл	Нөлөөллийн үнэлгээ		
				Их	Дунд	Бага
Агаарын чанар /үйлдвэрийн дотоод орчны агаар/	Үйлдвэрийн агаарын чанарт сөргөөр нөлөөлөх	C- болзошгүй	C3	+		
	Ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	C- болзошгүй	C3	+		
Агаарын чанар /агуулахын дотоод орчны агаар/	Агуулахын агаарын чанарт сөргөөр нөлөөлөх	D-бага	D3		+	
	Галын аюул, бүтээгдэхүүний чанар өөрчлөгдөх, химийн бодис алдагдах	D- бага	D3		+	
Агаарын чанар /химийн бодис импортлосон тээвэрлэх үйл ажиллагаа/	Агуулахын агаарын чанарт сөргөөр нөлөөлөх	D- бага	D3		+	
	Тархмал шинж чанартайгаар агаарын чанарт сөргөөр нөлөөлөх	C- болзошгүй	C1			+
Газрын доорх усны нөөц	Гүний усны хомсдол үүсэх	C- болзошгүй	C3	+		

Хүний эрүүл мэндэд нөлөөлөх байдлын үнэлгээ

Үйл ажиллагаа	Боломжит / болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн тохиолдолын магадлал/ давтамж	Зэрэглэл	Нөлөөллийн үнэлгээ		
				Их	Дунд	Бага
Химийн бодисын буруу хадгалалт	Хүний эрүүл мэнд болон үйлдвэрийн эд хогшил, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх	E- ховор	C3	+		
Химийн бодисын тээвэрлэлт	Хүний амь нас эрсдэх	E- ховор	D3	+		
Хүний буруутай үйл ажиллагаа	Хүний эрүүл мэнд болон үйлдвэрийн эд хогшил, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх	E- ховор	D3		+	
Үйлдвэрлэл	Хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учруулах	D- бага	C3	+		

3. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

Зорилго, зорилт: АйВиКо ХХК нь 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол Улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг мөрдлөг болгон боловсруулж, төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхийг гол зорилго болгосон.

Хамрах хүрээ: “АйВиКо” ХХК-ны Тарилгын эмийн үйлдвэр нь ЭМЯ-ны “Эм үйлдвэрлэх ҮХ-05/23/3210” тусгай зөвшөөрөлтэйгээр холбогдох хууль тогтоомжийн дагуу тарилгын эм үйлдвэрлэх, эрүүл мэндийн байгууллага хүн амыг хангах үйл ажиллагаа явуулдаг бөгөөд энэхүү төслийн БОННУТ-г холбогдох хууль, журмын дагуу БОАЖЯ-аар батлуулсан.

2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд үйл ажиллагаа болон төслийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг нэгтгэсэн болно.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 7,020,000 төгрөг төсөвлөгдөж байгаа ба үүнээс сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд 3,600,000 төгрөг, осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд 1,900,000 төгрөг, орчны хяналт шинжилгээний зардалд 1,520,000 төгрөгийг тус тус төлөвлөсөн. Нөхөн сэргээлтийн баталгаа төлбөр болох 3,510,000 төгрөгийг холбогдох дансанд байршуулсан.

2023 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан нийт 19 ажлын гүйцэтгэл 100% бөгөөд нийт 50,847,330 төгрөг зарцуулсан байна. Үүнд:

№	Хөрөнгийн зориулалт	Төсөвлөсөн хөрөнгийн хэмжээ, ₮	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, ₮
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	3,600,000	5,745,600
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	-	8,000,000
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-	-
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,900,000	27,329,000
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг		7,826,390
6	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	1,520,000	1,946,340
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага-зохион байгуулалтын төлөвлөгөө	-	-
8	БОМТ-г орон нутагт тайлагнах	-	-
	Дүн	7,020,000	50,847,330

5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Биелэлт
1	Химийн бодисын буруу хадгалалт, үйлдвэрлэлээс үүдэн химийн бодис алдагдах агаарын чанарт сөргөөр нөлөөлөх, Хог хаягдлыг тээвэрлэхгүй удах зэргээр агаарын чанарт нөлөөлөл үүсгэх	Ажилчдын хэрэглээнээс гарах хог хаягдлыг сар бүр тээвэрлэн зайлуулж байх	Үйлдвэр болон агуулах	Сард 2 удаа	Ажилчдийн хэрэглээнээс гарсан хог хаягдлыг 2023 оны 2 сарын 27 өдөр ЭКО ХОТЫН ТЭЭВЭР ААТҮГ-тай хийсэн 23/89 тоот гэрээний дагуу сар бүр тээвэрлэн зайлуулдаг бөгөөд 2023 оны 11 сарын байдлаар нийт 10 удаагийн тээвэрлэлт хийлгэж, 5,745,600 төгрөг төлсөн болно.
2		Химийн бодис, материалын хадгалалтын нөхцөлийн стандартыг нарийн баримталж уурших, халах, тэлэх нөхцөлөөс бүрэн сэргийлж ажиллах	Үйлдвэр, лаборатори, агуулах	Тухай бүр	ХАБЭА-н зөвлөх гэрээт ажиллантай болсон бөгөөд химийн бодисын агуулахыг стандартад нийцүүлэх, уурших, халах, тэлэх нөхцлөөс сэргийлэх үүднээс өдөр бүр хяналт тавин ажиллаж байна.

6. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Биелэлт
1	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн	Шилмүүст мод тарих	СХД, 211 хороо, "Инчон мөрөөдлийн төгөл"	Монгол улсын ерөнхийлөгч У.Хүрэлсүх нь цөлжилт, газрын доройтол, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд уриалсан бөгөөд уг хөдөлгөөний хүрээнд Сонгинохайрхан дүүргийн 21 хороонд байрлах “Инчон мөрөөдлийн төгөл”-д 100 ширхэг шилмүүст мод 2023 оны 10 сарын 14 өдөр тарьсан. Нийт зардал: 7,000,000
2	Хөрсний үржил шимтэй байдлыг хадгалах, агаарт тоосжилт бохирдолд үүсэхээс урьдчилан сэргийлэх	Зүлэгжүүлэлт хийх	Өөрийн эзэмшлийн газар	Хөрсний үржил шимтэй байдлыг хадгалах, агаарт тоосжилт бохирдолд үүсэхээс урьдчилан сэргийлж, өөрсдийн ажиллах орчин нөхцлийг сайжруулах үүднээс өөрийн эзэмшлийн 12.5 м² талбайг зүлэгжүүлсэн. Нийт зардал: 1,000,000

7. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

“Айвико” ХХК-ийн Тарилгын эмийн үйлдвэр төслийн бүс нь төв суурины бүс, хүн амын суурьшилт бий болоод удаж байгаа ба энэ хугацаанд ямарваа нэгэн түүх, соёлын дурсгалт зүйлс, эртний олдворууд олдсон тохиолдол байхгүй тул энэ талаар мөн тусгаадаагүй.

8. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Биелэлт
1	Химийн бодис их хэмжээгээр асарвал аюултай нөхцөл байдал үүснэ.	Химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хоосон сав, бортого, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг багаж хэрэгслийг ажлын талбарт бэлэн байлгах	Лаборатори болон агуулах	Эрсдэлийн үнэлгээний дагуу звлөх гэрээт ажилтантай болсон бөгөөд химийн бодис, материалын хадгалалт болон ашиглалтын аюулгүй байдалд эрсдлийн үнэлгээ хийлгэж, химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хориглох тэмдэг зэрэг багаж хэрэгслийг тухай худалдан авч, ажлын талбарт байршуулсан.
2		Химийн бодистой зөв харьцах, хадгалах, ашиглах талаар агуулахын ажилчдад сургалт зохион байгуулах	Үйлдвэр, лаборатори, агуулах	Монголын химич, химийн инженер технологийн холбооноос зохион байгуулсан Химийн хорт болон аюултай бодистой харьцан ажиллагсдын сургалтанд 6 ажилтанг хамруулсан. Нийт зардал: 600,000 төгрөг
3	Хөдөлмөр хамгааллын дүрэм алдагдах, ажиллагсад хамгаалах хэрэгсэл бүрэн ашиглаагүйгээс зэргээс үүдэн химийн бодисын нөлөөнд өртөж болзошгүй	Ажиллагсдыг эмнэлгийн үзлэг хамруулах /урьдчилан сэргийлэх багц үзлэг шинжилгээг хийлгэх/	Үйлдвэр, лаборатори, агуулах	Эм үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага MNS 5524:2014" стандартад заасны дагуу ХУД-ийн ЭМТөвтэй хамтран ажиллах гэрээ байгуулан 2023 онд 98 ажилтнуудыг 2 удаа үзлэг, шинжилгээнд хамруулсан. Нийт зардал: 4,600,000 Мөн Эм үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага MNS 5524:2014" стандартад заасны дагуу харааны нарийн мэдрэхүй шаардагддаг ажлын байранд ажилладаг 32 ажилтныг нүдний нарийн үзлэг шинжилгээнд хамруулсан. Нийт зардал: 960,000 2023 оны 3 сард нийт 106 ажилтнуудыг УНТЭ дээр урьдчилан сэргийлэх багц үзлэг шинжилгээнд хамруулсан. Нийт зардал: 6,000,000
4		Ажилчдад хор тайлах бүтээгдэхүүн олгож байх /витамиажуулсан ундаа олгох/	Үйлдвэр, лаборатори, агуулах	Химийн бодисын нөлөөнд өртөж болзошгүй эрсдлээс сэргийлэх үүднээс ажилчдад ногоон цай, аарц, чацарганы шүүс зэрэг хор тайлах бүтээгдэхүүнийг өдөр бүр олгож байна. Мөн хүйтэн сэрүүний улиралд ханиад томуунаас сэргийлэх үүднээс дархлаа дэжих бүтээгдэхүүн олгодог. Нийт зардал: 14,136,000 төгрөг
5	Химийн бодис галд өртөж шатвал аюултай нөхцөл байдал үүсч болзошгүй.	Галын хорыг цэнэглэж лаборатори болон агуулахад зохих байршилд байрлуулах.	Үйлдвэр, лаборатори, агуулах	Үйлдвэр, лаборатори болон агуулахад байршуулсан галын хорыг цэнэглэлтийг сар бүр шалгаж, шаардлагатай тохиолдолд цэнэглэж ажиллаж байна.
6	Химийн бодисын агуулахын аюулгүй байдал алдагдах	Химийн бодисын агуулахад тогтмол хугацааны давтамжтайгаар хяналт хийж, тэмдэглэл хөтлөх	Үйлдвэр, лаборатори, агуулах	Эмийн түүхий эд болон химийн бодисын агуулахын температур, харьцангуй чийгшлийг тухай бүр хэмжиж бүртгэдэг. Сар бүр эмийн түүхий эд болон химийн бодисын хадгалалт

				болон үлдэгдэлд тооллого хийх замаар хяналт тавьж ажиллаж байна.
	Лабораторид өргөн хэрэглэдэг химийн бодисын анхааруулах бодисын анхааруулах болон аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээ болон хор аюулын лавлах мэдээллийг бодис тус бүрээр ERP-программад оруулсан. ERP-программад эдгээр мэдээллийг оруулснаар холбогдох ажилтнууд хэдийд хаанаас ч тус мэдээллийг авах боломжтой болсон.	Лаборатори	Лабораторид өргөн хэрэглэдэг химийн бодисын анхааруулах болон аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээ бүхий самбарыг шинээр хийх	Мөн химийн бодис хийх зориулалтын шүүгээг авч химийн бодисуудыг өнгөөр ялган хадгалах нөхцлийг бүрдүүлсэн. Нийт зардал: 1,033,800

9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа
1	Аюултай	Химийн бодисын сав баглаа боодлын хог хаягдлыг Цэцүүх трейд ХХК-тай байгуулсан гэрээний дагуу шилжүүлэх	Үйлдвэр, лаборатори	Цэцүүх трейд ХХК-тай "Аюултай хог хаягдал шилжүүлэх Ш-20/19", "Аюултай хог хаягдал тээвэрлэх Т-20/005" тоот гэрээний хугацаа дууссан. Иймд Түмэн элшиг ХХК-тай "Аюултай хог хаягдал шилжүүлэх" №2023/11 тоот гэрээг 2023.11.06 өдөр байгуулсан. Энэхүү гэрээний дагуу аюултай хаягдлыг тусгай зөвшөөрөл бүхий тус компанийн тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлүүлэн хүргэж байна. 2023 оны 11 сард тус онд гарсан химийн бодисын хуванцар сав зэрэг аюултай хаягдлыг гэрээний дагуу шилжүүлээд байна. Нийт зардал: 683,100
		Химийн аюултай хог хаягдал гарсан тохиолдолд хог хаягдлын хайрцаг, сав баглаа боодол дээр аюулаас сэрэмжлүүлсэн тусгай таних тэмдэг, нэр хаяг хадах тусгасан болно.	Лаборатори	Хог хаягдлын журамд химийн аюултай хог хаягдал гарсан тохиолдолд хог хаягдлын хайрцаг, сав баглаа боодол дээр аюулаас сэрэмжлүүлсэн тусгай таних тэмдэг, нэр хаяг хадах тухай нэмж тусгасан болно.
		Аюултай хог хаягдлын бүртгэлийг батлагдсан маягтын дагуу хөтлөх	Лаборатори	Аюултай хог хаягдлын бүртгэлийг тээвэрлэх тухай бүртээ гэрээгээр батлагдсан маягтын дагуу хөтлөж байна.
2	Үйлдвэрийн	Үйлдвэрлэлийн явцад гарсан хог хаягдлыг гэрээний дагуу Элемент ХХК-тад шилжүүлэн устуулах	Үйлдвэр	Үйлдвэрлэл болон лабораторийн шинжилгээний явцад гарсан эмнэлгийн гаралтай, эрсдэлтэй хог хаягдал (тариур, зүү, эмийн сав баглаа боодол, тэжээлт орчин)-ыг тээвэрлэх, халдваргүйжүүлэх устгах, аюулгүй болгох гэрээг 2023 оны 9 сард Элемент медикал ХХК-тай байгуулсан гэрээг сунгуулсан. Уг гэрээний дагуу Үйлдвэрлэл болон лабораторийн шинжилгээний явцад гарсан эмнэлгийн гаралтай, эрсдэлтэй хог хаягдлыг 7 хоног бүр шилжүүлэн устуулж байна. Нийт зардал: 7,143,290

	Хог хаягдлын бүртгэл хөтлөх, тайлан мэдээг гаргах	Үйлдвэр	Хог хаягдлыг гэрээт компаниар тухай бүр ачуулж, төлбөр тооцоог хийж, бүртгэлийг тухай бүр хөтлөн баримтжуулж байна.
3	Ахуйн хог хаягдлыг дүүргийн ТҮК-тай байгуулсан гэрээний дагуу зайлуулна	Үйлдвэр	Ахуйн хуурай хог хаягдлыг түр хадгалах зориулалтаар ангилан хадгалах бетонон суурьтай тасалгаатай хогийн саванд ангилан, Ажилчдийн хэрэглээнээс гарсан хог хаягдлыг 2023 оны 2 сарын 27 өдөр ЭКО ХОТЫН ТЭЭВЭР ААТҮГ-тай хийсэн 23/89 тоот гэрээний дагуу сар бүр ангилсан хог хаягдлыг ачиж тээвэрлүүлж байна.
4	Эрүүл, хоггүй орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлэх Халтиргаа гулгаанаас сэргийлэх	Эв нэгдлийн гудамж 200 м	Эрүүл, хоггүй орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлэх үүднээс “Хоггүй Хан-Уул 2023 ая”-ны хүрээнд дараах цэвэрлэгээг хийж ажиллаж байна. Үүнд:
		Өөрийн эзэмшлийн газар	1. 2 удаа эв нэгдлийн гудамж дахь замын дагуух 200 м газрын зэрлэг ургамлыг түүж, хог хаягдлыг цэвэрлэж, гарсан хог хаягдлыг ачуулсан.
		Өөрийн эзэмшлийн газар	2. Сар бүр өөрийн эзэмшлийн гудамж талбайн хог хаягдал, зэрлэг ургамлыг цэвэрлэж, хог хаягдлыг ачуулж ажиллаж байна. 3. Өвлийн улиралд халтиргаа гулгаанаас сэргийлэх үүднээс өөрийн эзэмшлийн гудамж талбайн цас мөсийг тогтмол цэвэрлэж байна.

10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

БОХТ-тэй холбогдон удирдамж болох үйлдвэр, агуулахын үйл ажиллагаанаас байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг үнэлэн, “Айвико” ХХК-ний хэрэгжүүлэх ОХШХ боловсруулав. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт агуулахын дотоод орчны агаарын чанарын хяналт шинжилгээ хийх, хугацаа, давтамж, холбогдох стандарт зэргийг тодорхойлж, хяналт шинжилгээ хийхэд гарах зардлыг тооцон дараах хүснэгтэд үзүүлэв.

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Биелэлт
1	Агаарт дэгдэмхий органик нэгдэл - Азотын давхар исэл, NO2 - Озон, O2 - Формальдегид, CH2O - Бензол - Трихлорэтилен - Толуол - П-ксилол - М-ксилол - Стирол – 1,4- дихлорбензол - 1,2- дихлорбензол	Үйлдвэр, лаборатори, агуулах	Жилд 1 удаа	Агаарт дэгдэмхий органик нэгдэл хамгийн их байх эрсдэлтэй цэг буюу лабораторийн агаарт дэгдэмхий органик нэгдлийн шинжилгээг Холбогдох стандартын дагуу Ногоон титэм ХХК лабораториор хийлгэсэн. Шинжилгээний дүнг тайланд хавсаргав. Шинжилгээний төлбөр: 1,188,000
2	Цэвэрлэгээнээс гарч буй саарал усанд шинжилгээ хийлгэх	Үйлдвэр, лаборатори	Жилд 1 удаа	Үйлдвэрлэлийн дараа цэвэрлэгээнээс гарч буй саарал ус болон ундны уснаас тус тус дээж авч Ханлаб ХХК лабораторид шинжлүүлсэн. Уг шинжилгээний дүнг тайланд хавсаргав. Шинжилгээний төлбөр: 758,340

11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Биелэлт
1	Галын аюулгүй байдал, авах арга хэмжээ сэдвээр сургалт хийх	Нэхэмжилсэн дүнгээр	2023 оны 9 сард ХУД-ийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран Галын аюулгүй байдал сэдэвт сургалт зохион байгуулсан

12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

№	БОМТ-ний Хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Биелэлт
1	Нийслэлийн Байгаль орчны газар, Хан-Уул дүүргийн ЗДТГ	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, иргэдийн төлөөлөгчдийн хурлаар оруулж танилцуулах	Тайланг eic.mn цахимаар хүргүүлсэн
2	Төрийн захиргааны төв байгууллага /БОАЖЯ/	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлэх	Тайланг eic.mn цахимаар хүргүүлсэн

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын/Journal No: 000419041496

Системийн огноо/System Date: 2023.03.21 15:41:46

Дт/From	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5022465896	АЙ ВИ КО ХХК	3,510,000.00 MNT	1.00
/ Гурван сая таван зуун арван мянган төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No	Банкны нэр Bank Name		
	90	Төрийн Сан		
	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name		
	100900013406	БО нөхөн сэргээх баталгаа	3,510,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-БО Нөхөн сэргээлтийн барьцаа-Айвико ХХК

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэр/Signature:

Тамга/Stamp:

_____ Он/Year (YYYY) _____ Сар/Month (MM) _____ Өдөр/Day (DD)

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2018 оны 02 сарын 02-ны өдрийн А/21 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАЯГДЛЫН ТАГАЛДАХ БИЧИГ

№ 9/0933

Дагалдах бичгийн дугаар:

шаардамжтай тохиололдо нэмэлт хуудас хэрэглэнэ

1. Үүсгэгчийн талаарх мэдээлэл: Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар: Аюултай хог хаягдал үүсгэгч байгууллагын нэр: ИСО ХХК								
2. Аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгсөн: Овог нэр Албан тушаалтан Гарын үсэг: Огноо: ХОВАН 2023 он 11 сар 11 өдөр								
3. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл: 1/ Тээврийн хэрэгслийн улсын дугаар 18-14764 Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар: 0000022								
4. Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл:								
	Аюултай хог хаягдлын нэр	Аюулын ангилалын зэрэглэл	Савлагаа ны бүлэг	Савны дугаар	Төрөл	Хэмжээ	Нэгж /кг Эсвэл/ ш	Аюултай хог хаягдлын код
1	Хөдсгөм сав	Х				88	кг	150120
2	Хөдсгөм сав	Х				276	кг	150106
3								
4								
3. Тээвэрлэх үед анхаарах нэмэлт зааварчилгаа, мэдээлэл: Овог нэр: ХОВАН								
5. Аюултай хог хаягдлыг хүлээн авсан тээвэрлэгч: Овог нэр: Түмэн Эгшиг ХХК								
1. Овог нэр: Б.Оздоб Гарын үсэг: 2023 он 11 сар 11 өдөр								
6. Үл зохицол:								
8. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчийн талаарх мэдээлэл: Аж ахуйн нэгжийн нэр: ТҮМЭН ЭГШИГ ХХК Түмэн эгшиг ХХК бүртгэлийн дугаар: -000022 Аюултай хог хаягдлыг хүлээн авсан: Овог нэр: Түмэн эгшиг ХХК Албан тушаал Гарын үсэг/тамга: Огноо: 2023 он 11 сар 11 өдөр								



НОГООН ТИТЭМ ХХК
Хан-Уул дүүрэг, 3-р хороо,
Сан-Констракин ХХК байр, 222 тоот.
Утас: 70005432



ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ТАЙЛАН TEST REPORT OF LABORATORY

Ажлын дугаар *Registration number*: 230905

Сорилтын төрөл *The type of test*: Агаар /air/

Захиалагчийн мэдээлэл: Айвико ХХК

The name of customer's request for analysis

Түүвэр дээжийн мэдээлэл *Sample details*: УБ, ХУД, 3-р хороо, Айвико ХХК-н үйлдвэрийн лабораторийн дотоод орчноос агаарын сорьц цуглуулсан.

Түүвэр дээж цуглуулсан цэгийн тоо *Number of sampling point*: 1

Түүвэр дээжийн тоо *Number of sample*: 15

Сорьц цуглуулсан арга *Sampling method*: MNS 3384:1982

Түүвэр дээж цуглуулсан хүн *Sample is collected by*: Б.Баттуяа

Түүвэр дээж цуглуулсан огноо <i>Date of collected</i>	Лабораторид хүлээн авсан огноо <i>Date of receipt</i>	Сорилт эхэлсэн огноо <i>Date of test started</i>	Сорилт дууссан огноо <i>Date of completion</i>	Хэвлэсэн огноо <i>Date of issue of the report</i>
2023-09-05	2023-09-05	2023-09-05	2023-09-07	2023-09-07

Сорилтын дүн <i>Result</i>				
Түүвэр дээжийн дугаар <i>Sample number</i>	Тодорхойлох үзүүлэлт <i>Test parameter</i>	Сорилтын аргын стандарт <i>Method of analysis</i>	Сорилтын дүн, хэмжих нэгж <i>Test results unit</i>	Байршил <i>Collected location</i>
8575	Азотын давхар исэл <i>NO2</i>	MNS ISO 6768:2005	16.99 мкг/м³ <i>μg/m³</i>	Айвико ХХК-н лаборатори
8576	Хүхэрлэг хий <i>Sulfur dioxide SO2</i>	ISO 6767:1990	145.78 мкг/м³ <i>μg/m³</i>	Айвико ХХК-н лаборатори
8577	Озон <i>Ozone O3</i>	MNS 5063:2001	2.02 мкг/м³ <i>μg/m³</i>	Айвико ХХК-н лаборатори
8578	Аммиак <i>Ammonia NH3</i>	MNS 0012-062:1991	187.92 мкг/м³ <i>μg/m³</i>	Айвико ХХК-н лаборатори
8579	Формальдегид <i>Formaldehyde</i>	NIOSH 3500	1.13 мкг/м³ <i>μg/m³</i>	Айвико ХХК-н лаборатори
8580	Бензол <i>Benzene</i>	NIOSH 1501	<0.5 мкг/м³ <i>μg/m³</i>	Айвико ХХК-н лаборатори
	Толуол <i>Toluene</i>	NIOSH 1501	44.18 мкг/м³ <i>μg/m³</i>	
	Этилбензол <i>Ethylbenzene</i>	NIOSH 1501	<0.5 мкг/м³ <i>μg/m³</i>	
	М,п ксилол <i>m,p-xylene</i>	NIOSH 1501	<0.8 мкг/м³ <i>μg/m³</i>	
	о ксилол <i>o-xylene</i>	NIOSH 1501	<0.8 мкг/м³ <i>μg/m³</i>	
8581	Хүхэрт устөрөгч (*) <i>Hydrogen sulfide H2S</i>	MNS 4991:2000	0.00 мкг/м³ <i>μg/m³</i>	Айвико ХХК-н лаборатори
8582	Нүүрсхүчлийн хий (*) <i>Carbon dioxide CO2</i>	MNS 4991:2000	2919471.84 мкг/м³ <i>μg/m³</i>	Айвико ХХК-н лаборатори
8583	Нүүрстөрөгчийн дутуу исэл (*) <i>Carbon monoxide CO</i>	MNS 4991:2000	<1 ppm <i>ppm</i>	Айвико ХХК-н лаборатори

Лабораторийн дотоод хяналт			
№	Нэгдлийн нэр	Стандарт уусмалын агуулга	Сорилтын утга, хэмжих нэгж
1	Азотын давхар исэл	0.600	0.599 мкг/мл
2	Хүхэрлэг хий	16.334	16.754 мкг
3	Озон	0.0945	0.093 мкг
4	Аммиак	0.013	0.01257 мг
5	Формальдегид	0.601	0.600 мкг/мл
6	Бензол	200 ± 3	205.33 мкг/мл
7	Толуол	199 ± 3	195.21 мкг/мл
8	Этилбензол	201 ± 4	198.32 мкг/мл
9	м,п ксилол	400 ± 8	409.32 мкг/мл
10	о ксилол	200 ± 4	203.21 мкг/мл

"(*) Энэхүү үзүүлэлт нь MNAS-аар (Mongolian National Accreditation System) итгэмжлэгдээгүй болно."

Санал тайлбар:

Opinions and interpretation

ГҮЙЦЭТГЭСЭН: ХИМИЧ :

Analysed by

ХЯНАСАН: ХИМИЧ :

Reviewed by

БАТАЛСАН: ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР:

Approved by



Signature

/Г.ХУЛАН/

/Б.БАТТУЯА/

/АЛТАНГАДАС/

Энэхүү сорилтын дүн нь сорилт хийсэн тухайн сорьцонд хамаарах бөгөөд зөвхөн эх хувь хүчинтэй. Сорьц цуглуулалт, тээвэрлэлттэй холбоотой захиалагчаас ирүүлсэн аливаа мэдээлэлд хариуцлага хүлээхгүй болно.



ХАНЛАБ ХХК
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг. 17 р хороо, Богд Жавзандамба
гуудамж 34/6 тоот, Хан Рашаан компанийн байр
Утас: 70109968, 99995316
<http://www.khanlab.mn>



ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

ЗАХИАЛАГЧИЙН НЭР: **АЙВИКО ХХК**

ДЭЭЖИЙН ТӨРӨЛ,
ТОО

Ус, 2

ЗАХИАЛГА №: 2023/1776

ХҮЛЭЭН АВСАН ОГНОО: 2023.10.05

ШИНЖИЛСЭН ОГНОО: 2023.10.24

ДЭЭЖ БОЛОВСРУУЛАЛТ: **хийгдээгүй**

ХУУДАСНЫ ТОО: 2

Сорилтын үр дүн зөвхөн тухайн дээжинд хамаарна.
Дээжлэлтийн талаарх асуудлыг манай лаборатори харнуцахгүй болно.

Чанарын менежер:



Д.Пүрэвжаргал

Хамтран ажилласан таньд талархлаа.

ЗАХИАЛГА №: 2023/1776

ДЭЭЖИЙН ДУГААР: Шугам угаалтын ус

ЛАБОРАТОРИЙН ДУГААР: ЛЛ-19665

№	ЭЛЕМЕНТ	НЭГЖ	ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН	ЗӨВШӨӨРӨГДӨХ ХЭМЖЭЭ /MNS 4943:2015/	СТАНДАРТ АРГА
1	pH	-	7.80	6-9	MNS ISO 10523:2001
2	Чөлөөт хлор, Cl _{хол}	мг/л	<0.10	1.0	MNS 4423:1997
3	Хуурай үлдэгдэл, TDS	мг/л	166.0	1000	
4	Умбуур бодис, TSS	мг/л	<3.0	30	
5	Исэлдэх чадвар /KMnO ₄ /	мгO ₂ /л	2.56	20	
6	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч, COD	мгO ₂ /л	<20.0	50	MNS ISO 6060:2001
7	Биологийн хэрэгцээт хүчилтөрөгч, BOD	мгO ₂ /л	<3.0	20	MNS ISO 5815:2001
8	Хүхэргүстөрөгч, H ₂ S	мг/л	<0.10	0.5	MNS 5597:2006
9	Хром, Cr (VI)	мг/л	<0.05	0.01	MNS ISO 11083:2001
10	Хөнгөнцагаан, Al	мг/л	<0.025	0.5	MNS (ISO) 11885:2011
11	Мышьяк, As	мг/л	<0.01	0.01	
12	Бор, B	мг/л	<0.01	0.50	
13	Барн, Ba	мг/л	<0.01	1.5	
14	Берелли, Be	мг/л	<0.001	0.001	
15	Кобальт, Co	мг/л	0.001	0.02	
16	Кадм, Cd	мг/л	<0.005	0.03	
17	Хром, Cr	мг/л	<0.005	0.3	
18	Зэс, Cu	мг/л	<0.02	1.0	
19	Төмөр, Fe	мг/л	<0.03	1.0	
20	Марганец, Mn	мг/л	<0.01	0.5	
21	Молибден, Mo	мг/л	<0.005	0.5	
22	Никель, Ni	мг/л	<0.005	0.2	
23	Фосфор, P	мг/л	<0.05	1.5	
24	Хартугалга, Pb	мг/л	<0.01	0.1	
25	Сурьма, Sb	мг/л	<0.01	0.05	
26	Селен, Se	мг/л	<0.01	0.02	
27	Стронци, Sr	мг/л	<0.01	2.0	
28	Ванади, V	мг/л	<0.01	0.10	
29	Уран, U	мг/л	<0.10	0.05	
30	Цайр, Zn	мг/л	<0.01	3.0	
31	Цианид, CN _{тох}	мг/л	<0.002	0.050	MNS ISO 6703(1):2006
32	Цианид, CN _{нөө}	мг/л	<0.002	0.050	MNS ISO 6703(1):2006
33	Мөнгөн ус, Hg	мг/л	<0.001	0.005	MNS ISO 4420:1997



ЗАХИАЛГА №: 2023/1776

ДЭЭЖИЙН ДУГААР: Хотыг ус

ЛАБОРАТОРИЙН ДУГААР: Л-19666

№	ЭЛЕМЕНТ	НЭГЖ	ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН	ЗӨВШӨӨРӨГДӨХ ХЭМЖЭЭ /MNS 4943:2015/	СТАНДАРТ АРГА
1	pH	-	6.99	6-9	MNS ISO 10523:2001
2	Чөлөөт хлор, Cl _{вал}	мг/л	<0.10	1.0	
3	Хуурай үлдэгдэл, TDS	мг/л	164.0	1000	MNS 4423:1997
4	Умбуур бодис, TSS	мг/л	<3.0	30	
5	Исэлдэх чадвар /KMnO ₄ /	мгO ₂ /л	3.12	20	
6	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч, COD	мгO ₂ /л	<20.0	50	MNS ISO 6060:2001
7	Биологийн хэрэгцээт хүчилтөрөгч, BOD	мгO ₂ /л	<3.0	20	MNS ISO 5815:2001
8	Хүхэртүстөрөгч, H ₂ S	мг/л	<0.10	0.5	MNS 5597:2006
9	Хром, Cr (VI)	мг/л	<0.05	0.01	MNS ISO 11083:2001
10	Хөнгөнцагаан, Al	мг/л	<0.025	0.5	
11	Мышьяк, As	мг/л	<0.01	0.01	
12	Бор, B	мг/л	<0.01	0.50	
13	Барн, Ba	мг/л	0.02	1.5	
14	Берелли, Be	мг/л	<0.001	0.001	
15	Кобальт, Co	мг/л	0.001	0.02	
16	Кадми, Cd	мг/л	<0.005	0.03	
17	Хром, Cr	мг/л	<0.005	0.3	
18	Зэс, Cu	мг/л	0.03	1.0	
19	Төмөр, Fe	мг/л	<0.03	1.0	
20	Марганец, Mn	мг/л	<0.01	0.5	MNS (ISO) 11885:2011
21	Молибден, Mo	мг/л	0.02	0.5	
22	Никель, Ni	мг/л	<0.005	0.2	
23	Фосфор, P	мг/л	<0.05	1.5	
24	Хартугалга, Pb	мг/л	0.01	0.1	
25	Сурьма, Sb	мг/л	<0.01	0.05	
26	Селен, Se	мг/л	<0.01	0.02	
27	Стронци, Sr	мг/л	0.36	2.0	
28	Ванади, V	мг/л	<0.01	0.10	
29	Уран, U	мг/л	<0.10	0.05	
30	Цайр, Zn	мг/л	0.10	3.0	
31	Цианид, CN _{тох}	мг/л	<0.002	0.050	MNS ISO 6703(D):2006
32	Цианид, CN _{бсс}	мг/л	<0.002	0.050	MNS ISO 6703(D):2006
33	Мөнгөн ус, Hg	мг/л	<0.001	0.005	MNS 4420:1997





ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

ДЭЭЖИЙН ТӨРӨЛ, ТОО: Бохир ус, 2

ЗАХИАЛАГЧИЙН НЭР: АЙВИКО ХХК

ДЭЭЖИЙН ХЭМЖЭЭ, мл: 500

№	Лаб №	Дээжийн тодорхойлт	ҮЗҮҮЛЭЛТ
			Гэдэсний бүлгийн эхлэг төрөгч нян (Salmonella)
1	Л-1583	Хотын ус	илрээгүй
2	Л-1584	Шугам угаалт	илрээгүй
ШИНЖИЛЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТ			MNS ISO 19250:2017
ЗӨВШӨӨРӨГДӨХ ДЭЭД ХЭМЖЭЭ /MNS 4943:2015/			илрэхгүй 1мл-д
Чанарын менежер			Д.Пүрэвжаргал

Сорилтийн тусламжийг эхний үеэс хамгаална.
Дээдэлтийн тусламж 35.86% хэмжээг харуулажгүй болно.

ДЭЭЖИЛСЭН ОГНОО: 2023.10.11

ШИНЖИЛГЭЭ ЭХЭЛСЭН ОГНОО: 2023.10.11

ШИНЖИЛГЭЭ ДУУССАН ОГНОО: 2023.10.19

ДЭЭЖ БОЛОВСРУУЛАЛТ: хийгдээгүй
ХУУДАСНЫ ТОО: 1

Хамтран ажигласан таньд талархлаа.

Хуудас 1-1